

## “Монголын уул уурхайн тоног төхөөрөмж” төсөл

Улс:	Монгол
Төслийн дугаар:	46394
Бизнесийн салбар:	Ашигт малтмал буюу байгалийн нөөц
Төрийн/Хувийн:	Хувийн
Байгаль орчны ангилал:	В
Захирлуудын Зөвлөлийн Хурал товлогдсон өдөр:	2014 оны 9-р сарын 17
Төлөв байдал:	Эцсийн хэлэлцүүлэг хийгдсэн, Захирлуудын зөвлөлийн хэлэлцүүлэг хүлээгдэж байгаа
Төслийн хураангуй нийтлэгдсэн огноо:	2014 оны 8-р сарын 1
Төслийн танилцуулга:	Энэхүү төслийг хэрэгжүүлэхэд зориулан ЕСБХБ нь 200 сая ам.доллар хүртэлх хэмжээний А/В ангиллын зээл олгохоор төлөвлөж байна. Уг зээлийн санхүүжилт нь Монгол улс дахь ЕСБХБ-ны харилцагчид болох Түрээслэгч - Лейтон ХХК болон Түрээслүүлэгч - Монголын арилжааны банк ХААН Банк нарыг хамруулан хэрэгжинэ. Санал болгож буй санхүүжилт нь Монгол улсын уул уурхайн салбарт одоогийн уул уурхайн бүтээгдэхүүний үнийн бууралтын үе шатыг даван туулахад үзүүлэх дэмжлэгээ нэмэгдүүлэх, Монгол дахь уул уурхайн компаниудад уул уурхайн зориулалттай тоног төхөөрөмж (цаашид “Шар Бүтээгдэхүүн” гэх)–ийн лизингийн үйлчилгээг танилцуулах зорилготой. Энэ нь тус улсын хэмжээнд хэрэгжиж буй Шар Бүтээгдэхүүний хамгийн анхны томоохон лизингийн үйлчилгээ болно.
Шилжилтийн үйл явцад үзүүлэх нөлөөлөл:	Төслийн хүрээнд үзүүлэх шилжилтийн үеийн гол нөлөөлөл нь санхүүжилтийн шинэ төрөл, стандартчилал тогтоох болон зах зээлийн тэлэлтийг нэвтрүүлсний үр дүнд бий болох үр нөлөө байна. Уг төслөөр дамжуулан санхүүжилтийн шинэ төрөл хэлбэрийг танилцуулах ба энэ нь Монгол улсын хэмжээнд хийгдэж буй анхны Шар Бүтээгдэхүүний томоохон лизингийн санхүүжилт болох юм. Санхүүжилт нь уул уурхайн бүтээгдэхүүний үнийн бууралтын мөчлөгийн үед хийгдэж байгаагаараа илүү ач холбогдолтой бөгөөд санхүүжилт хийгдсэнээр хөрөнгө оруулагчдад дотоодын уул уурхайн салбарт хөрөнгө оруулахад дэмжлэг үзүүлэх болно. Эцэст нь уг төсөл дотоодын түрээсийн компаниудад шаардлагатай мэдлэг, ур чадварыг дамжуулан эзэмшүүлэхэд хувь нэмэр оруулна.
Харилцагч:	ХААН Банк нь Монгол улсын хэмжээнд хамгийн том арилжааны банк, Лейтон ХХК нь дэлхийн хамгийн том уул уурхайн гэрээлэн гүйцэтгэгч компани болох Лейтон Холдингс Лимитед - ийн охин компани юм.
ЕСБХБ-наас олгох санхүүжилт:	200 сая ам.долларын А/В ангиллын зээл
Төслийн нийт өртөг:	200 сая орчим ам.доллар
Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл:	В Ангилал. Уул уурхайн тоног төхөөрөмжийн түрээсийн үйл ажиллагаанаас байгаль орчин болон нийгэмд үзүүлэх

	<p>нөлөөллийн эрсдэл нь тухайн байршлаасаа хамааран харилцан адилгүй бөгөөд нарийвчилсан судалгаа хийсний дараа хэрэв шаардлагатай бол Харилцагч болон Банк хооронд харилцан тохиролцож хүлээн зөвшөөрсөн “Үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулж хэрэгжүүлэх замаар үүссэн хор хөнөөллийн талаар арга хэмжээ авах боломжтой. Тэрхүү нарийвчилсан судалгаа нь Байгаль орчин, Эрүүл мэнд, Аюулгүй байдал болон Нийгмийн (“БОЭМАБН”) чадавх боломж, шинээр үүсгэж буй Лизингийн компанийн санал болгож буй бодлого, үйл ажиллагааны арга зарчим, Монгол дахь түрээслэгч компани болох Лейтон ХХК –ийн үйл ажиллагаанд голлон анхаарал хандуулна. ХААН Банк болон Лейтон ХХК хоёрын хувьд аль аль нь ЕСБХБ-тай өмнө нь харилцаж байсан туршлагатай, танил харилцагч нар бөгөөд хоёулаа БОЭМАБН-ийн эрсдэлийн удирдлагын цогц, үр дүнтэй тогтолцоог байгууллагын түвшинд нэвтрүүлэн хэрэгжүүлж ирсэн. Лейтон ХХК байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд болон аюулгүй байдлын асуудлуудын хүрээнд боловсруулагдсан санал асуулгад бүрэн хариулсан ба ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны чиглэлд цаашид авч хэрэгжүүлэх бодлого журмынхаа талаар мэдээлэл өгсөн байна. Ийнхүү өгсөн мэдээлэл нь нэлээд цогц, дэлгэрэнгүй байсан бөгөөд одоогоор ЕСБХБ-ны Байгаль орчин, Нийгмийн Хэлтэс нь хийгдэх ёстой нарийвчилсан судалгааг дуусгавар болгоход шаардлагатай хэд хэдэн асуудлуудыг тодруулах, нарийвчлан судлах ажлыг гүйцэтгэж байна. Түүнчлэн нарийвчилсан судалгааны дагуу ХААН Банк өөрийн баримталдаг компанийн БОЭМАБН-ийн эрсдэлийн удирдлагын бодлого, арга туршлагыг Лизингийн компанийн үйл ажиллагаанд мөн адил нэвтрүүлж, баримталж ажиллана гэсэн баталгаа гаргаж өгөх юм.</p>
Техникийн хамтын ажиллагаа:	Компанийн чадавх бэхжүүлэх чиглэлд техникийн хамтын ажиллагаа явуулах талаар судалж байна.
Компанийн харилцах хаяг:	<p>ХААН Банк ХХК</p> <p>Сөүлийн гудамж – 25, Шуудангийн Хайрцаг – 192</p> <p>Улаанбаатар – 44, Монгол улс</p> <p>Утас: + 976 11 332333 3044</p>
Бизнес хамтын ажиллагаа:	Бизнесийн боломжууд болон худалдан авалтын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар харилцагч компанитай холбогдоно уу.
Ерөнхий лавлагаа авах:	<p>ЕСБХБ-наас төсөлтэй холбоотой лавлагаа (ажил үйлчилгээ худалдаж авахтай холбоогүй) авах хаяг:</p> <p>Утас: +44 20 7338 7168; Факс: +44 20 7338 7380</p> <p>Цахим шуудан: <a href="mailto:projectenquiries@ebrd.com">projectenquiries@ebrd.com</a></p>
Олон нийтэд мэдээлэх журам (ОНМЖ):	<p>Олон нийтийн мэдээллийн журам (цаашид “ОНМЖ” гэх) нь ЕСБХБ-ны зүгээс холбогдох мэдээллийг олон нийтэд хэрхэн түгээх, хувь нийлүүлэгч, хамтрагч талуудтайгаа хэрхэн зөвшилцөх, өөрийн стратеги, бодлого, үйл ажиллагааг сурталчлах, ойлголт мэдлэгийг нь нэмэгдүүлэх талаар баримтлах зарчмуудыг тусган харуулсан байдаг.</p> <p>ОНМЖ-ыг дараах холбоосоор орж авна уу:  <a href="http://www.ebrd.com/about/policies/pip/index.htm">http://www.ebrd.com/about/policies/pip/index.htm</a></p>
Төслийн талаарх санал гомдлын механизм (ТТСГМ)	ЕСБХБ нь өөрийн санхүүжүүлсэн төслүүдийн үйл ажиллагаанаас хэн нэгэнд ямарваа хор хохирол учруулсан буюу учруулж болзошгүй талаар нэг буюу түүнээс олон тооны хувь хүн, албан байгууллагын зүгээс мэдүүлсэн гомдлыг хараат бус байдлаар нэг бүрчлэн авч үзэх, хянах боломжийг олгох үүднээс Төслийн талаарх санал гомдлын механизм (цаашид “ТТСГМ” гэх)-ийг бий болгосон. ТТСГМ-

---

ын үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг Дотоод дүрэм журмыг Англи хэл дээр [www.ebrd.com/downloads/integrity/pcmrules.pdf](http://www.ebrd.com/downloads/integrity/pcmrules.pdf), холбоосоор, Орос хэл дээр <http://www.ebrd.com/downloads/integrity/pcmrulesr.pdf> холбоосоор орж авна уу.

ТТСГМ-ын дагуу аливаа гомдлыг ЕСБХБ-ны санхүүжилтийн сүүлийн хуваарилалт хийгдсэнээс хойш 12 сарын дотор бүртгэгдэхшаардлагатай. Гомдлоо ямар хугацаанд хэрхэн ирүүлэх талаар тодруулах, туслалцаа авахыг хүсвэл [pcm@ebrd.com](mailto:pcm@ebrd.com) хаягаар ТТСГМ-ын ажилтантай холбогдох буюу ЕСБХБ-ны төлөөлөгчийн газарт хандана уу.

---